



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Т.АУБАКИР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.01.22 № 03

Малчны тухай хуулийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу дараах асуултыг тавьж байна.

Улсын Их Хурлын малчин, малчин өрхийн ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч малчны эрх зүйн байдлыг тодорхойлсон Малчны тухай хуулийг 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр батласан. Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 308.8 мянган малчин, 195.8 мянган малчин өрх байгаагаас баруун бүсэд 77.7 мянган малчин, 48.3 мянган малчин өрх амьдарч байна.

Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлд Малчдын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон бөгөөд 4.2.9 дэх хэсэгт “хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх”, 4.3 дахь хэсэгт “Энэ хуулийн ..., 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.”, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө” гэсэн заалтуудын биелэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хүсэж байна.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЗАЯАБАЛ

2026000007